

## МОНГОЛ УЛСЫН ОЛОН ТУЛГУУРТ ГАДААД БОДЛОГО ХЯТАДЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ НЬ

*Ли Дазунь\**

*Жан Зеньпин\*\**

*Ван Синь\*\*\**

Ойр орчмын аюулгүй байдлын орчин нь стратегийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг, нэн чухал хүчин зүйл билээ. Манай хойд хөрш Монгол Улс нь хүчин чадал буурай орон, түүний чиг хандлага нь манай одоогийн стратегийн судалгааны гол анхааралд байдаггүй. Гэвч аюулгүй байдлын орчин гэдэг нь хөдлөшгүй ойлголт биш бөгөөд тоо цөөн байна гэдэг хувьсах хэмжээ бага байна гэсэн утга биш билээ. Сүүлийн үед Монгол Улс геостратегийн онцгой байрлалаа ашиглан “олон тулгуурт” гадаад бодлогыг хүчтэй хэрэгжүүлсэнээр дэлхийн гол орнуудын харааг булааж буй, ялангуяа АНУ Монгол Улсыг өөрийнхөө Зүүн хойт Ази руу нэвтрэх шинэ гарц болгон хараад байна. Иймээс олон улсын ээдрээ нугачаат өнөөгийн нөхцөлд Монгол Улсын гадаад бодлого манай ойр орчмын аюулгүй байдалд хэрхэн нөлөөлөхийг стратегийн өндөрлөгөөс анхаарч байх нь нэн чухал бодит ач холбогдолтой юм.

### Монгол Улсын олон тулгуурт гадаад бодлого

Монгол Улс нь /хойшид Монгол гэх/ Азийн эх газрын төв хэсэг, Монголын өндөрлөгийн хойд хэсэгт оршдог, уулархаг, өмнөд хэсгийн говийн бүс нь нийт нутгийн гуравны нэгийг эзэлнэ. Нутаг дэвсгэр нь 1.56 сая хавтгай дөрвөлжин км, 2.42 сая хүн амтай. Монгол баруун, зүүн, өмнөд гурван талаараа Хятадтай хиллэдэг, хилийн шугам 4676 км. Хойд талаараа ОХУ-тай 3485 км-ээр хиллэдэг. Монголын газар зүйн онцгой байршил нь евроазийн эх газарт геостратегийн чухал байрлал болж өгдөг. Монгол далайд гарцгүй эх газрын орон, мал аж ахуй голлосон эдийн засагтай, нэг хүнд ноогдох ДНБ 440 ам.доллар,

\*Ли Дазунь /1954/ эрэгтэй, Бээжин хүн, Батлан хамгаалахын Их сургуулийн Стратеги судлалын салбарын профессор. Судалгааны чиглэл: Гадаад орнуудын цэргийн стратеги

\*\*Жан Зеньпин /1977/ эрэгтэй, Өвөр Монгол Хөх хотын хүн, Батлан хамгаалахын Их сургуулийн Стратеги судлалын салбарын магистр, дэслэгч цолтой. Судалгааны чиглэл: Цэргийн стратеги

\*\*\*Ван Синь /1975/ эмэгтэй, Шаньдун муж Циндао хотын хүн. Циндао Их сургуулийн Анагаахын сургуулийн Сургалтын салбарын шинжээч. Судалгааны чиглэл: Хүмүүнлэгийн шинжлэх ухаан

ДНБ нь 1 тэрбум ам.доллар юм. 2004 онд гадаад өр нь 1 тэрбум ам.доллар /ОХУ-д 17 тэрбум ам.долларын зээл/ байлаа.

Монгол нь /тухайн үед Гадаад Монгол гэх/ Чин гүрний харьяанд байсан бөгөөд хятадын дотоодод дайн самуунтай, хүчин буурай, төвлөрөл сул болох үед Хаант Орос, хуучин ЗХУ-ын бодлогоор аажим салан тусгаарласан. 1945 оны 10-р сарын 20-нд тусгаар тогтнолын бүх нийтийн санал хураалт явуулж, тусгаар тогтносон төрт улс болсон юм. Монгол Улс гадаад бодлогын хувьд хуучин ЗХУ-ын талыг олон жилийн турш баримталж ирсэн. ХХ зууны 60-аад онд Хятад, Зөвлөлтийн харилцаа муудсанаас хойш Монгол нутаг дээрээ Зөвлөлтийн цэрэг байршуулахыг зөвшөөрч хуурай замын, агаарын цэрэг, зэвсгийн бааз байгуулан улмаар арми командлах эрхийг Зөвлөлтөд олгож Хятадын хилийн дагууд байршуулах болсон юм. ЗХУ задарсанаар Зөвлөлтийн цэрэг Монголоос гарсан билээ. Хэдэн арван жил Монгол нь ЗХУ-ын эдийн засаг, улс төрийн дагуул улс байсан ба ЗХУ задарсаны дараа эдийн засаг нь доройтож, 1991 онд үндэсний орлого нь 1990 оны 87.2 хувьтай тэнцэж, аж үйлдвэрийн бүтээгдэхүүн 1985 оны төвшинд болсон байлаа. Энэ бүхний эсрэг Монгол гадаад харилцааны стратегиа бүхлээр нь шинэчлэхэд хүрч Монголын албаныхны хэллэгээр “Өөрийнхөө толгойгоор сэтгэж асуудлыг шийдэх цаг иржээ”.

ЗХУ задарсаны дараа Монгол жинхэнэ утгаар бие даасан гадаад бодлого явуулах болж, “эвсэлд үл нэгдэх, олон талт” гадаад харилцааны чиг тогтоон Хятад, Оростой найрсаг хөршийн харилцааг хөгжүүлэхийг гадаад бодлогынхоо тэргүүлэх зорилт болгосны зэрэгцээ Япон, Герман болон Энэтхэг, Солонгос зэрэг өрнө, дорнын орнуудтай харилцаагаа идэвхижүүлж, ялангуяа АНУ-ыг “гуравдагч хөрш” хэмээн үзэх болсон. Монгол үүнийгээ “олон тулгуурт гадаад бодлого”, “аюулын эсрэг гурваас дээш тулгууртай байж тогтвортой байдлыг хадгалж чадна” хэмээн дүрсэлж буй юм. Монгол Улсын Их Хурлаас 1994 онд баталсан “Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал”-д үүнийг тодорхой зааж өгчээ. 2001 онд Н.Багабанди ерөнхийлөгчөөр сонгогдсоны дараа олон талт гадаад харилцааны стратегийг улам эрчимжүүлжээ. Монголын удирдлагууд “дэлхий эдүгээ олон туйлт хандлага руу чиглэж буй үед Монгол шиг жижиг орон олон улсын аюулгүй байдлын гадна зогсож болохгүй”, “олон талт гадаад стратеги нь үндэсний аюулгүй байдлаа сахин хамгаалах үр ашигтай арга зам мөн” гэдгийг тодорхой харж байна. “Олон тулгуурт” гадаад стратегийн гол цэг нь Монголын АНУ, Орос, Хятад бүгдтэй нь холбогдох геополитикийн онцгой ашиг

сонирхол бөгөөд түүний шинж чанар нь олон талт гадаад харилцаандаа геополитикийн ашиг сонирхолыг үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолоор орлуулж тавихад оршиж байна. Гэхдээ 2004 оны парламентийн сонгуулиар эрх баригч хувьсгалт нам ялагдаж, АНУ-ыг дотночлогч Эх орон-ардчилал эвсэл гарч ирсэнээс үзвэл, ирээдүйд Монголын гадаад бодлого АНУ руу хандах нь улам илэрхий болж байна.

### **Манай орны ойр орчмын аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл ба нөлөөлж болох хүчин зүйл**

Олон тулгуурт гадаад бодлогын дагуу Монгол нь АНУ, Японтой цэрэг, улс төр, эдийн засгийн харилцааг өргөжүүлж, манай Тайваньтай эдийн засаг худалдаагаар харилцаж, АНУ, БНСУ-ын заавраар Умард Солонгосын дүрвэгсдийн асуудалд оролцож байна. Энэхүү үйлдэлүүд нь манай орны ойр орчмын аюулгүй байдалд шинэ хувьсагдахуун гаргаж буй нь эргэлзээгүй бөгөөд тодорхой нөлөө үзүүлж байна.

Нэг. АНУ Монголын цэргийн салбарт улам нэвтэрч буй

Сүүлийн үед хамтын эрх ашгийн дор Монгол, АНУ-ын хоёр талын хамтын ажиллагаа гүнзгийрч, ялангуяа АНУ Монголтой цэргийн хамтын ажиллагаа хөгжүүлж, үзүүлэх тусламжаа улам бүр нэмэгдүүлж байна.

*АНУ Монголын цэргийн харилцааны байдал:* 1994 оны 4 сард АНУ Номхон далайн бүсийн ерөнхий командлалын “Эвслийн стратегийн систем”-д Монголыг оруулахаар шийдвэрлэж, АНУ-ын талаас Монголын цэргийн сургуулийн хичээлийн программ, сургалтын тогтолцоо, сургуулилтын хэлбэр зэрэгт шууд зааварчилга өгч эхэлсэн юм. 1996 оны сүүлээр Монгол УИХ “Монгол, АНУ-ын Засгийн газар хоорондын цэргийн харилцааны хэлэлцээр”-ийг баталж, шаардлагатай үед АНУ түр хугацаагаар Монголын цэргийн байгууламжийг ашиглаж болохыг заажээ. 2000 оны 8-р сард Номхон далайн бүсийн ерөнхий командлалын захирагч Д.Блэйр болон АНУ-ын БХЯ-ны төрийн нарийн бичгийн даргын орлогч У.Слоком нар тус тус айлчилж, Монгол, Америкийн аюулгүй байдлын тогтолцооны яриа хэлэлцээрийн механизмыг сайжруулав. 2003 оны 9 сард 180 монгол дайчин АНУ-ын цэргийн зориулалттай тээврийн онгоцоор Иракт очиж Польшийн цэргийн удирдлага дор нефтийн хоолойн эргүүл хамгаалалтын үүргийг гүйцэтгэв. Монгол Ирак руу цэрэг илгээн энхийг сахиулах үүрэг гүйцэтгэсэн нь Бушийн засгийн газраас “ихээхэн талархал” хүлээсэн юм. 2004 оны 10 сард АНУ-ын Зүүн Ази ба Номхон далайн хэрэг хариуцсан Төрийн нарийн бичгийн туслах Жэймс Келли Монголд

айлчилж, Монгол улсын ерөнхийлөгч Н.Багабанди, УИХ-ын дарга Н.Энхбаяр, ерөнхий сайд Ц.Элбэгдорж нартай халуун дотно уулзаж ярилцан, хоёр орны бүх талын түншлэлийн харилцааг хөгжүүлэх, улс төр, цэрэг, эдийн засаг, соёлын зэрэг салбарын харилцаа хамтын ажиллагааг гүнзгийрүүлэхийг талууд илэрхийлсэн юм.

*АНУ, Монголын цэргийн хамтарсан сургуулилт:* Сүүлийн жилүүдэд АНУ, Монгол жил бүр “Balance magic” хэмээх хамтарсан сургуулилтыг зохион явуулж байгаа ба 2003 оноос хамтарсан сургуулилт бодит дэвшилд хүрч байна. 2003 оны 8-р сард АНУ-ын тэнгисийн болон хуурай замын цэргийн салбар Монголд “Хааны эрэлд-03” хамтарсан цэргийн сургуулилт хийсэн нь Америк, Монголын хооронд явуулсан хамгийн өргөн хэмжээний хээрийн сургуулилт байлаа. Монголын БХЯ-ны сайд Б.Эрдэнэбат, Төрийн нарийн бичгийн дарга Х.Баасанхүү, ЗХЖШ-ын дарга Ц.Тогоо, АНУ-аас Монголд суугаа элчин сайд П.Слуц нар сургуулилтыг ажиглав. 2004 оны 5 сарын 13-аас 27-ны өдрүүдэд Тайландын зүүн хойд хэсэгт зохиогдсон АНУ, Тайландын хамтарсан “Кобра” хэмээх жил бүрийн сургуулилтад Монгол оролцсон. “Кобра” хамтарсан сургуулилтад Монгол анх удаагаа оролцсон нь АНУ, Монголын цэргийн хамтын ажиллагаа улам гүнзгийрч, АНУ-ын Азийн цээжинд цэргийн давуу тал олж стратегийн нөлөөгөө бэхжүүлэх гэсэн стратеги санааг улам тод илэрхийлж байна.

*АНУ-ын Монгол дахь цэргийн тусламжийн байдал:* 1990 оноос хойш АНУ Монголд хэдэн зуун сая ам.долларын зээл, 100 сая ам.долларын технологи эд материалын тусламж үзүүлсэн байна. 1998 онд М.Олбрайт Монголд айлчлахдаа 15 сая ам.долларын цэргийн тусламж үзүүлсэн юм. АНУ 2001 оны санхүүгийн жилд батлан хамгаалахын төсөвтөө нэгэн шинэ зүйл нэмсэн нь Монголын хилийн эргүүл шалгалтын цэрэгт 2 сая ам.долларын мэдээлэл холбооны тоног төхөөрөмжийн тусламж үзүүлэх явдал байлаа. Энэ тоо АНУ-ын Ази тив дэх цэргийн тусламжийн тал хувь болж буй юм. Үүнээс гадна АНУ, Монголын армийн энхийг сахиулах бэлтгэл, англи хэлний сургалтад зориулан тусламж үзүүлж, хилийн бүс нутагт эргүүлийн утасгүй холбоо нийлүүлж, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлж байна. АНУ-ын гадаад дахь цэргийн тусламжийн ажилтаны хэлсэнээр Монголын говь цөлийн хилийн бүсэд үзүүлж буй “тоног төхөөрөмжийн тусламж”-д электрон хянагч төхөөрөмж суурилалт зэрэг багтаж буй, “АНУ мөн Монголд армийг хэрхэн шинэчлэх талаар санал өгч байгаа юм”.

АНУ-ын Монгол дахь үйл ажиллагааны санаархал нэн тодорхой

бөгөөд, зарим мэргэжилтний дүрсэлдэгээр “тахиааны нуруун дээрх чулуу /хятадын газрын зураг нь тахиааны хэлбэртэй/” юм. АНУ, Монголын харилцаа, ялангуяа АНУ, Монголын цэргийн хамтын ажиллагааг нэн анхаарах шаардлагатай. Хэрэв АНУ-ын цэргийн хүчин Төв Азийн Монголд бүрэн нэвтэрч Монголд цэрэг орших нь биелэх аваас АНУ-ын манай дахь У хэлбэрийн стратегийн хяналтын хүрээ бүтэн тойрог хэлбэрт орж, манай харьцангуй тогтвортой хойд хэсгийн стратегийн орчин эвдэгдэн аюулгүй байдлын орчин улам муудах төлөвтэй болно.

Хоёр. Монгол, Японы харилцааг шинээр хөгжүүлэхийг Япон хичээж байна

1991 оноос Япон жил бүр Монголд хандивлагчдын олон улсын зөвлөлгөөнийг зохион байгуулж, эдүгээ 2.1 тэрбум ам.долларыг монголд өгөхөөр болгуулаад байна. Түүнээс Японы тусламж 40 хувийг эзэлж буй юм. 2003 оны 12 сарын 4-нд Японы ерөнхий сайдын өргөөнд Монголын ерөнхийлөгч Н.Багабанди Коизумитай уулзаж ярилцсан. Уулзалтын төгсгөлд талууд мэдэгдэл хийж, Монголын тал Японыг НҮБ-ын Байнгын гишүүн орон болоход нь дэмжлэг үзүүлэхээ илэрхийлсэн билээ. Япон нь ЗХУ задарсаны дараа Азийн цээжинд эрх мэдлийн вакуум үүссэнийг ойлгож өөрийн эдийн засгийн чадал, цэргийн хүчээр нөлөөгөө Монголд нэвчүүлсэнээр Хятад, Оросын араар орсон өргөс лугаа болж стратегийн энэ хоёр том гүрнийг аргамжин, тэдэнтэй харилцах харилцаанд илүү өргөн уян хатан орон зайг олж буй юм. Үүний зэрэгцээ Япон Монголд эдийн засгийн тусламж үзүүлснээр Монголын байгалийн баялгийг ашиглах, улс төрийн их гүрэн болоход жин нэмэх зэрэг нэг сумаар олон туулай онилж байна. Япон нь хойшид Монголтой харилцаагаа бэхжүүлэх нь гарцаагүй бөгөөд Монгол дахь нөлөөгөө өсгөсөөр байх болно.

Гурав. Тайвань Монгол дахь худалдаа эдийн засгийн харилцаагаа ашиглан улс төрийн эрх ашиг олж авахаар оролдож буй нь

Тайвань “оршин тогтнох орон зай”-гаа тэлэх үүднээс 2000 онд Монголтой “Хэрэг эрхлэх газар”-аа харилцан нээх асуудлыг эхлүүлсэн. 2002 онд Монгол, Тайвань худалдааны төлөөлөгчийн газраа харилцан нээснээ мэдэгдэв. “Тайбэйн эдийн засаг, худалдааны төв” нь Тайваний “ГЯЯ”-нд харьяалагдаж, “Ерөнхийлөгчийн ордон”-ны удирдлага дор байдаг. “Төлөөлөгчийн газар” нь Тайваний бизнес эрхлэгчдэд зөвлөлгөө өгөх, аялал жуулчлал, визийн үйлчилгээ зэргийг үзүүлэх бөгөөд мөн ихэнхдээ улс төрийн үйл ажиллагаа явуулдаг. 2002 оны 9 сарын 5-ны орчим Тайваний 30 шахам бизнес эрхлэгч Монголд болсон “2002 оны

Монголын Олон улсын түншлэл үзэсгэлэн”-нд оролцсон. Монголын Засгийн газар Тайваний бизнес бүрэлдэхүүнийг Монголын нийслэл Улаанбаатарт зохиогдсон “Монгол Улс-Гадаадын хөрөнгө оруулагчдын чуулга”-д оролцохыг урьсан. Гэхдээ Тайвань, Монгол хоёр “Төлөөлөгчийн газар”-аа харилцан нээж монголын ажиллах хүч зэрэг худалдаа эдийн засгийн нөхцлийг хөзөр болгон гарч ирсэн юм. Тайвань нь Тайвань, Монголын “бодит харилцаа”-г дээшлүүлэхээр чармайж байгаа нь үнэндээ “гадаад харилцааны дэвшил”-ийг эрэлхийлж, олон улсын нийгэмлэгийн хязгаарт хаягдахгүй гэсэн хэрэг. Харин Монгол олон тулгуурт гадаад бодлогын хүрээнд нэг хятад зарчмыг барьж Тайваний тусгаар тогтнолыг дэмждэггүй, үүний зэрэгцээ мөн Тайваньтай улс төрийн бус харилцааг бүр мөсөн орхихгүй юм. Эндээс Монгол, Тайванийн харилцаа ялангуяа худалдаа, эдийн засгийн харилцаа цаашид үргэлжлэх боловч чанарын хүчтэй өөрчлөлт гарахгүй гэдгийг харж болно.

Дөрөв. Монгол Умард Солонгосын дүрвэгсдийн асуудлыг ээдрээтүүлж байгаа нь

Умард Солонгосын цөмийн асуудал үүссэнээр АНУ, БНСУ нь Монголын Засгийн газарт шахалт үзүүлж, Монголыг Умард Солонгосын дүрвэгсдийг хүлээн авах хуаран байгуулна гэж найдаж байгаа. АНУ-д “Улс ард түмний төлөө зовнигч эмэгтэйчүүдийн холбоо” гэгч хүний эрхийн байгууллага залбиралын бүлэг байгуулж, “хэлмэгдсэн” умард солонгосын христчүүдийн төлөө залбирал үйлдэж байна. АНУ-ын оюутнуудын байгуулсан “Умард Солонгосыг чөлөөлөх” байгууллага саяхан Нью-Йорк, Лос Анжеласт жагсаал зохион байгуулж, манай орныг Умард Солонгосын дүрвэгсдийг нутагт нь буцааж байна хэмээн эсэргүүцсэн юм. Дүрвэгсдийг дэмжигч АНУ-ын бүлэгүүд дэлхийн хоёрдугаар дайны үед Португали төвийг сахисан шиг Монгол дүрвэгсдийг хүлээн авч, “НҮБ-ын дүрвэгсдийн асуудал эрхэлсэн ерөнхий газар”-аас дүрвэгсдийг хүлээн авч зохицуулан гуравдагч орон руу гаргах хүртэл дамжлага болно гэж найдаж байгаа юм. АНУ Умард Солонгосын дүрвэгсдэд зориулж жил бүр 20 сая ам.доллар гаргадаг. БНСУ мөн дүрвэгсдийг нууцаар дэмжиж, Өмнөд Солонгост дүрвэж гарсан умардын хүн бүрт 40 сая воныг “амьдрах” тэтгэлэг болгон өгч байна. АНУ, БНСУ-ын эдгээр үйлдэл нь манай орны ойр орчмын аюулгүй байдалд ихээхэн нөлөө үзүүлэх ба “Умард Солонгосын цөмийн асуудал”-ын ээдрээ Зүүн хойт Азийн аюулгүй байдлыг урьд байгаагүйгээр хурцатгаж байх агаад Умард Солонгос нь манай орны Зүүн хойт Ази дахь

стратегийн зөөлөвчийн хувьд тэдний дотоодын тогтвортой байдал нь манай аюулгүй байдлын орчинд асар их нөлөөтэй. Дүрвэгсдийг хүлээн авах Монголын бодлого АНУ, БНСУ-ын дэмжлэгтэйгээр бүрдүүт Умард Солонгосын дүрвэгсэдийн урсгал манай орноор дайран өнгөрч, улмаар Умард Солонгосын улс төрийн дотоод тогтвортой байдалд ноцтой нөлөө үзүүлэн, манай дотоодын аюулгүй байдалд нилээд хэмжээгээр хохирол үзүүлэх юм. Монгол татагдан орвол Солонгосын хойгийн асуудлыг улам төвөгтэй болгох бөгөөд дүрвэгсэдийн хуарангийн асуудал аливаа нөхцөлд гинжин хэлхээт аюулыг дагуулж манай зүүн хойд бүсийн аюулгүй байдлыг муутгаж болохыг харж болохоор байна.

### Саналууд

Монголын олон тулгуурт гадаад бодлого, “дипломат замаар үндэсний аюулгүй байдлаа хамгаалах” гадаад стратегийг баталсаны объектив шалтгаан нь хүчин чадал буурай байдал болон геополитикийн онцгой нөхцөл юм, субъектив шалтгаан нь Монгол нь Хятад, Орос хоёрыг өөрийн бодит аюул хэмээн хардагт байгаа юм. Эндээс улбаалаад бид асуудлыг үндэсээс нь эхлэн, идэвхигүй хөтлөгдөх байдал үүсэхээс сэргийлэн, санаачлагатай хандан өөрчилж, манайд хандах “сэрэмжлэл”-ийг арилган, улмаар гадаад стратегиа өөрчлөхөд нь нөлөөлөх хэрэгтэй.

#### Нэг. Хоёр талын улс төрийн итгэлцэлийг бэхжүүлэх

1994 онд Хятад, Монгол хоёр улс “Хятад, Монголын найрсаг харилцаа хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийг баталж, хоёр талын эрүүл саруул хөгжилд улс төр, эрх зүйн үндсийг тавьсан билээ. 1998, 1999 онуудад Н.Багабанди ерөнхийлөгч, Зян Земинь дарга нар харилцан амжилттай айлчлал хийж, харилцааны хөгжлийн чигийг улам тодруулж өгсөн юм. 2003 оны 6 сард Ху Зиньтао дарга Монголд амжилттай айлчилж хоёр талын улс төрийн итгэлцэлд бодит суурь тавьсан. Гэвч Монгол “Хятад, Орос ижил нэгдүгээрт, гуравдагчийг хайж хоёрыг тэнцвэржүүлэх” гэсэн сэтгэлгээний хүрээ огт өөрчлөгдөөгүй ба цаад ойлголтоор манай орныг хамгийн их аюул авчрах орон гэж үзэж байна. Хятад нь энх тайвныг эрхэмлэгч, найрамдлыг дээдлэгч социалист системт хөгжиж буй орон, “таван зарчим”-ыг улс орны харилцааг зохицуулах зарчим болгон баримталдаг. Ойрын хөршүүд болох Хятад, Монгол хоёр уламжлалт хил хягаартай, ашиг сонирхлын нэгдэл ихтэй бөгөөд улс төрийн итгэлцэлийг хөгжүүлэх нь хоёр талын үндэсний эрх ашигт нийцэж, хамтын амжилтад хүрэх улс төрийн нөхцөл байдалд ашигтай юм. Хятад, Монголын итгэлцлийг бэхжүүлэхэд нэгд, хоёр орны

дээд төвшний харилцан айлчлал, харилцааг нэмэгдүүлж, айлчлал хэлэлцээрийн албан ёсны механизмыг бий болгож, улс төрийн хамтын ажиллагаа харилцааг бэхжүүлж, үл ойлголцлыг арилгах, хоёрт, хоёр талын болон олон талт хамтын ажиллагааг нэмэгдүүлж, газар зүйн онцгой байрлал давуу талаа ашиглан хамтын ажиллагааг ойлголцол, үүрэг, хөгжил болгох юм. Мөн манайд хандах “сэрэмжлэл”-ийг аажим саармагжуулан, “найрсаг хөрш, энх тайван хөгжил” хэмээх манай бодлогыг ойлгуулан, хоёр орны стратегийн харилцаа хамтын ажиллагааг хамгийн дээд хэмжээнд эрэлхийлэх хэрэгтэй.

#### Хоёр. Галуудын эдийн засгийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх

Монгол эх газрын орны хувьд байгалийн баялаг дан төрөлтэй, улсын хүчин чадал сайнгүй. Хуучин ЗХУ-ын дэмжлэг тусламжийг авахаа больсноос хойш дотоодын эдийн засгаа хөгжүүлж эдийн засгийн чадавхиа нэмэгдүүлэхийн тулд Монгол Зүүн хойт Азийн эдийн засгийн хүрээнд даруй оржээ. Сүүлийн жилүүдэд Монгол нь Хятадын эдийн засагт түшиглэх нь улам бүр ихсэж байна. Хятад хэдийнээ Монголын хамгийн том худалдааны түнш, хөрөнгө оруулагч болоод байгаа агаад Тяньжиний боомт Монголын далай дахь гол гарц болсон. 2004 оны 9 сард Ерөнхийлөгч Н.Багабанди Хятадад айлчлахдаа Хятадтай аялал жуулчлал, эдийн засгийн харилцааг өргөжүүлж, Хятадад илүү их нефть нийлүүлэх хүсэлтэй байгаа гээд Хятад улсын бодлого болон хөрөнгө санхүүгээр Монголын төмөр, нүүрс, нефть зэрэг байгалийн баялгийг нээж ашиглахад дэмжлэг үзүүлнэ гэж найдаж байгаагаа илэрхийлсэн юм. Хятад, Монголын эдийн засгийн харилцааг хөгжүүлэх нь хоёр орны ард түмний хамтын эрх ашигт нийцэх бөгөөд Монголын эдийн засгийн хөгжилд тустай, манай орон түүний байгалийн баялгийг ашиглахад хэрэгтэй, улмаар монголын худалдаа манайд түшиглэх байдлыг нэмэгдүүлж, мөн Монголын эдийн засаг дахь өөрийн нөлөөгөө бэхжүүлж, эдийн засгийн хамтын ажиллагааг алхам алхамаар хэрэгжүүлж, хамтын ажиллагаагаар аюулгүй байдлаа нэмэгдүүлэх юм.

#### Гурав. Хятад, Монголын соёлын харилцаа

Сүүлийн жилүүдэд Хятад, Монголын харилцааны тасралтгүй хөгжлийг дагаад соёлын салбар дахь хамтын ажиллагааны орон зай улам тэлсээр байна. Хятад, Монголын хооронд монгол үндэстний адилхан амьдралын хэв маяг соёлын бүрэлдүүн байдаг, хоёр талын соёлын солилцоог нэмэгдүүлэх нь бүх талын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд тустай юм. 1998 онд Хятад, Монгол хоёр улсын хооронд “БНХАУ-ын ЗГ ба МУ-ын ЗГ харилцан эрдмийн зэрэг зөвшөөрөх тухай хэлэлцээр”, 2000 онд



“Хятадын буцалтгүй тусламжаар монгол оюутан сургах төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-нд талууд гарын үсэг зурсан, 2002-2003 онд ЗГ-ын зардлаар хятадад суралцагч монгол оюутан, мэргэжил дээшлүүлэгчийн тоо 180 болсон, хамтын ажиллагааны хандлага нэмэгдсээр байна. Гэвч тус салбарт тодорхой хэрэгжүүлж буй арга хэмжээ цөөн байгаа гэдгийг харах ёстой. Тухайлбал, АНУ, Орос хоёул Монголд монголтой хамтран телевиз байгуулсан байхад энэ салбарт манайх байхгүй байна. Иймд соёлын салбарын харилцааг хөгжүүлэхэд үндэстний шинж, тогтмол чанарыг барьж, засгийн газар хооронд, ард иргэд хоорондын соёлын солилцоог бэхжүүлэх, тогтмол хугацаанд үндэстний соёлын арга хэмжээг зохион явуулж, Хятадын соёлыг Монголд дэлгэрүүлэх юм.

Дөрөв. Цэргийн салбарт хамтран ажиллах ба хазаарлан барихыг хослуулах

Монголын газар зүйн онцлогоос шалтгаалан дэлхийн чухал гүрнүүд өөр өөрийн эрх ашгийн үүднээс янз бүрийн төвшинд Монголтой хоёр талын харилцааг хөгжүүлж, ялангуяа цэргийн харилцаа улам бүр идэвхижиж байна. Гадаадын цэрэг Монголд орших асуудалд манай тал үндэстнийхээ эрх ашгийн өнцгөөс хандаж, янз бүрийн цогц арга хэмжээгээр тогтоон барих шаардлагатай. Хүнд зэвсэг Монгол руу ороход Хятад юмуу Оросын агаарын хилээр дайрах учраас их хэмжээгээр оруулах боломж багатай хэдий ч хүчирхэг гүрэн Төв Азийн бүс нутагт хэдийнэ нэвтрээд Азийн төвд бэхлэлт байгуулаад авсан байгаа, тусгай анги, бага хэмжээний хуурай замын цэрэг монгол руу орох боломж их байгаа. Манай орны хувьд цэргийн аюулгүй байдлын үүднээс байдлыг дагуулан удирдах, бодлого оролцоог хослуулах, хамтран ажиллах, хазаарлан барих хоёрыг зэрэгцүүлэн, өөрт ашигтай цэргийн нөхцөлд хүрэх, бусад ашиггүй хүчин зүйлийн оролцоог арилгах, Монголтой хамтын ажиллагааны сувгийг тэлэх, мөн Монголын талаас хүсч болох тусламжийг тохируулан хангаж байх, олон аргыг зэрэг ашиглан өөрийн эрх ашгаа баталгаажуулах хэрэгтэй юм.

*Уг нийтлэл нь БНХАУ-ын Зилинь мужийн “Зуун хойд Ази судлалын төв”-өөс эрхлэн гаргадаг “Зуун хойд Азийн индэр” сэтгүүлийн 2005 оны 3-р сарын дугаарт нийтлэгдсэн. Нийтлэл бичигдсэн хугацаа: 2004.12.10*

Орчуулсан Б.Индра